




 **Үүсгэн байгуулагчийн сургаал**  

Бурханы хүүхэд болохоо мэдрэх

Бурханлаг чанараа нээх гэж хялбархнаар хэлээд байгаа ч, яавал бурханлаг чанараа нээж чадах вэ гэдэг чухал.

Юуны өмнө “Би бол Бурханы хүүхэд” гэж өөртөө хэлж, сэтгэлээсээ тэгж бодож, бат итгэх явдал юм. Тэгэх юм бол дахин залхуурч суух аргагүй болно. Уурлаж бухимдах ч үгүй.

Сэтгэл судлалын нэгэн багш “Далд ухамсар нь сэтгэлдээ төсөөлсөн үр дүнд хүргэх боломжийг нээж чаддаг учраас сайныг бодвол сайн үр дүн, мууг бодвол муу үр дүн бий болно.” гэж хэлсэн байдаг.

“Гадна төрх эмх цэгцтэй байх юм бол дотоод

сэтгэл аяндаа л өсөж хөгждөг.” гэсэн үг бий. Энэ нь Моритагийн анагаах арга хэмээх мэдрэлийн өвчнийг эмчлэх аргыг нээсэн Морита Масатакэгийн хэлсэн үг юм. Өөрөөр хэлбэл хувцсаа янзлаад, биеэ цэгцэлчих юм бол “Муу зүйл хийж болохгүй” гэсэн сэтгэхүй суугаад ирнэ гэсэн үг.

Тэгэхээр “Би бол Бурханы хүүхэд” гэсэн ухамсартай байх юм бол ямар ч боломжгүй зүйл хэлсэн хүнтэй инээмсэглээд “Энэ хүнд ч гэсэн сургаал дамжуулъя.” гэсэн нигүүлсэнгүй сэтгэлээр харилцаж чаддаг болох юм.

Living the Lotus Vol. 172 (2020.01)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд,

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаагай гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Жинхэнэ өөрийгөө олох

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Нэг жилийг хэрхэн өнгөрүүлэх вэ?

Шинэ жилийн баярын мэнд хүргэе.

Шинэ хаврыг өгүүлэх дараах дуу байдаг.

“Хэлбэр дүрс нь үгүй цаг хугацаа, нэг жил хоёр уудам баялаг чигээрээ өмнө минь харагдана.” (Сатоо Сатароо). Шинэ оныг дөнгөж угтаад байгаа бидний өмнө үнэхээр л баялаг бөгөөд цагаан цаас мэт “цаг хугацаа” цэлийн харагдаж байна.

Энэ шинэ жилийг жинхэнэ баялаг болгох хүмүүс бол зөвхөн бид өөрсдөө билээ. Өдөр тутамд уулзан учрах хүн, юмс үзэгдэл нь бидэнтэй шүтэн барилдлагын холбоотой үүсэн бий болдог. Цаашлаад, алс хол ертөнцийн явдал хүртэл бүгд өөртэй хамааралтай гээд бодоод үзэхээр энэ жилийг ямархан нэг жил болгох вэ гэдэг бүгд таны гарт бий гэж хэлж болохоор байна.

Мөн энэ нэг жилийн хугацаанд өөрийгөө хэрхэн хөгжүүлж, сайжруулах вэ гэдэг ч гэсэн чухал.

Лянхуа Судрын “Суралцагч, үл суралцагч нарт эш үзүүлснийг өгүүлэх бүлэг” нь Шагжамүни бурханр ганц хүү Рахула болон үргэлж дэргэд нь байсан дагалдагч Анандад хандан “Гарцаагүй бурханы хутаг олно.” хэмээн эш үзүүлдэг бүлэг юм. Шагжамүни бурхан Рахулад эш үзүүлэхдээ “Рахулагийн хийсэн нүдэнд харагдахгүй бурханы үйлийг зөвхөн би л мэднэ.” хэмээн магтдаг. Бурханы ном судлаач эрдэмтэн Масүтани Фүмио гуай Рахулагийн тухай хэлэхдээ, тэрээр Шаарипүтра шиг оюун ухаан төгөлдөр, Пүрүна шиг сургаал айлдахдаа мундаг байгаагүй ч “Түүний төлөө санаа зовох хүмүүсийн ач болон өөрийнхөө тэвчээр зүтгэлийн үр дүнд нүдэнд харагдахгүй үйл буюу шашны бүлгэмийнхээ дүрэм журмыг баримтлах тал дээр хамгийн нямбай нь” болтлоо өсөж хөгжиж чадсан гэж тэмдэглэсэн байдаг.

Шаарипүтра болон Пүрүна шиг оюун ухаан, авьяас чадвартай хүнийг хүндэтгэх нь мэдээжийн хэрэг боловч нөгөөтэйгүүр онцгой авьяас





чадваргүй байсан Рахулагийн хичээл зүтгэлийг ойлгон хүндэтгэх хүн ганц би биш гэж бодож байна. Түүнчлэн бид өөрсдийгөө хэрхэн хөгжүүлж, сайжруулах вэ гээд бодоод үзэхээр Рахула хэрхэн хичээж зүтгэж байсан юм бол гэж бодогдож байна.

Цагаан цайлганаар, төлөв даруухнаар

Шагжамүни бурханы шашны бүлгэмд нас болон энгийн нийгэм дэхь байр сууринаас үл хамааран, сахил хүртээд олон жил болсон нь эхлээд бурханы үйл хэрэгжүүлэх газар (хийд)-н өрөөг хэрэглэж болно гэсэн дүрэм байжээ.

Шагжамүни бурхан болон Рахула нар Ялгуугч хан хүүгийн цэцэрлэгт байсан үеийн нэгэн явдал. Рахулагаас ахмад шавь нар баясгалант хүрээнд иржээ. Рахула шууд л эелдэгээр тэдэнд өрөөгөө өгсөн тул өөрт нь унтах газар байсангүй. Тэгээд Рахула яах аргагүй Шагжамүни Бурханы өрөөний өмнө амарч байсан гэдэг.

Мөн түүнчлэн нэг хүн Рахулаг Шагжамүни Бурханы хүүхэд гэдгийг мэдээд бадар барьдаг аяга руу нь элс хийж, толгой руу нь цохисон ч гэж тэмдэглэгдсэн байдаг. Тэгсэн ч Рахула огт хөдөлгөөнгүй тэвчиж байжээ.

Рахулаг “Нүднээс далд бурханы ёсыг хамгийн сайн баримтлагч” хэмээн хүндэтгэн нэрлэдэг. Тэрээр Пүрүнагаас эхлээд олон ахмад шавь нарын заавар зөвлөгөөг байгаагаар хүлээн авч, төлөв даруу байж, хүн хараагүй байхад ч гэсэн сургаалыг чин сэтгэлээсээ сурч, хэрэгжүүлж байсан учраас ийнхүү сайшаагдсан гэж бодож байна. Шагжамүни бурханы том хүү болон мэндэлж, эгэл хүн байхдаа аав болох Шагжамүни бурханд “Хааны ордны эд хөрөнгийг надад өгнө үү” гэж хэлж байсан Рахула сахил хүртсэнээр, сургаал номыг өвлөн авах нь амьдарлынх нь утга учир гэдгийг ойлгожээ. Түүнээс хойш бие сэтгэлээ цэгнэж, үргэлж “Цагаан цайлган байя”, “Төлөв даруу байя” хэмээн шийдэж, зүгээр л чимээгүйхэн бурханы үйлийг хэрэгжүүлж байсан нь “Нүдэнд харагдахгүй бурханы үйл” өөрөөр хэлбэл Рахулаагийн хичээл зүтгэл байсан юм.

Түүнд хөрөнгөнд шунах сэтгэл, өөртөө харамсах сэтгэл, Шагжамүни бурханы хүү гэдгээрээ онгирох сэтгэл аль нь ч байгаагүй. “Нүдэнд харагдахгүй бурханы үйл”-ийг дахин давтан хийснээр Рахула бүх хүнд төрөлхийн байдаг бурханлаг чанарын гайхамшигийг ухаарч, шунал, уур, мунхаг зэрэг бие сэтгэлийн зовлонгоос ангижирч, “Жинхэнэ өөрийгөө олсон” гэдэг.

Ямар ч хүн жинхэнэ өөрийгөө олж чадна. Түүний нэгэн адил бид ч гэсэн цагаан цайлган сэтгэлтэй, төлөв даруу байж, “Нэг насны амьдрал өнөөдрөөс шалтгаална” гэдгийг санаж, гэрэл гэгээтэй, амар амгалан нэг жилийг бий болгохын төлөө хичээцгээе.

«Косей» 2020 оны 1 дүгээр сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Оройн Дээд Цагаан Лянхуа Судар Дэвадаттагийн тухай өгүүлэх 12 дугаар бүлэг (сүүлийн хагас)

Сайн ба муу үйл шунал, хүслээ хэрхэн залахаас шалтгаална

Бүх л хүнд шунал хүсэл байдаг. Бурханы үйлийг сахигч хувраг хүн шунал хүслээсээ бүрэн ангижирахын төлөө хичээн зүтгэх нь мэдээжийн зүйл боловч жирийн амьдралаар амьдрагч хүний хувьд энэ нь бараг боломжгүй. Боломжгүй зүйлийг хий гэж албадах нь байгалийн жамыг эсэргүүцэж байна гэсэн үг. Тиймээс Их хөлгөний сургаалаар дамжуулж энгийн хүмүүст шунал хүслийг зөв тийш нь чиглүүлэхийг сургасан. Жишээлбэл “Их ашиг орлого олмоор байна” гэсэн шунал хүслийг “Тэгвэл нийгэм, ертөнцийн төлөө зүтгэх хэрэгтэй” гэсэн зөв зам руу чиглүүлээд өгчих юм бол адилхан л ажиллаж хөдөлмөрлөн, их мөнгө олж байгаа ч, тэр нь сайн үйл болно гэсэн үг

Дэвадатта шунал хүслээ тэр чигээр нь илэрхийлсэн учир тэр нь “Муу үйл” болчихсон. Уг нь Их хөлгөний сургаалаар шунал хүслээ сайн сайхан тийш нь чиглүүлсэн бол тэр дороо л сайн үйл болох боломжтой байсан. Сайн, муу хүний ялгаа ердөө л энэ юм. Тиймээс Дэвадатта ч бурханы үйлийг сахиж, шунал хүслээ сайн тийш нь чиглүүлж чадвал шунал хүсэл нь шунал хүсэл биш болж, улмаар Бурхан болж чадах учиртай. Энэ бол энэхүү бүлгийн эхний хагасаас сурах ёстой хоёр дахь чухал зүйл юм.

Одоо үлдсэн хагас руугаа орё.

Билиг хурсан бодисадва далайн ёроол дахь лусын ордонд сургаал түгээх үйлээсээ буцаж ирсэн Манзушир бодисадвагийн ач гавьяаг магтан дуулж, “Далайд ямар сургаал айлдсан бэ?” хэмээн асуухад “Гагцхүү Гайхамшигт Ном Лянхуа Судар.” гэж хариулдаг. Цаашлаад “Хамаг амьтны дотор энэхүү сургаалын хүчээр үтэр түргэн бурханы хутгийг олж чадах хүн байна уу” гэж асууна. Манзушир бодисадва

“Байна. Найман настай лусын хааны охин байна.” гэдэг. Тэр агшинд лусын хааны охин гарч ирж, Шагжамүни бурханд мөргөн залбирдаг.

Түүнийг харж байсан Шаарипүтра өөрийн мэдэлгүй ам нээн, охинд хандан, “Бурханы гэгээрэл гэдэг бол тоо томшгүй олон жил сараар бурханы үйлд хичээн зүтгэж, зургаан барамидыг төгс хэрэгжүүлсний дараагаар л хүрдэг зүйл. Барцад ихтэй эмэгтэй хүн тийм амархан хүрч чадах зүйл биш.” гэж хэлжээ.

Охин түүнд хариу хэлэлгүй, гартаа барьж байсан нэгэн эрдэнэсийг Бурхан багшид өгөв. Тэр бол Гурван мянган их мянган ертөнцөд ч үнэлэгдэхээр үнэт нандин сувд байлаа. Бурхан багш түүнийг нь талархан хүлээж авдаг. Лусын охин, Билиг хурсан бодисадва ба Шаарипүтра





нар руу хараад, “Бурхан багш миний өгсөн сувдыг шууд хүлээн авлаа. Миний бурханы хутгийг олох түүнээс ч хурдан юм шүү.” гэж хэлнэ. Ингэж хэлээд шууд эрэгтэй хүүхэд болон хувирч, өмнө зүгийн Хиргүй хэмээх ертөнцөд бурханы хутгийг олоод, Цагаан Лянхуа Судрын сургаалыг айлдаж байгаагаа харуулна.

Тэр үзэгдлийг харж байсан Билиг хурсан бодисатва ч, Шаарипүтра ч, бусад олон хүмүүс ч бүгд маш их сэтгэл нь хөдөлж, энэхүү үйл явдлыг эрхэм нандин жинхэнэ үнэн хэмээн сэтгэлдээ гүн гүнзгийгээр хүлээн зөвшөөрдөг байна.

Эмэгтэй хүн бурханы хутаг олох

Эртний Энэтхэгт эмэгтэй хүн эрэгтэй хүнээс хамаагүй дорд, тэр чигээрээ нүгэл хурсан мэт үзэгдэж, аврахад тун бэрх гэсэн хатуу үзэл баримтлал тогтсон байсан. Бусад улс оронд ч гэсэн бараг адилхан байсан байх.

Тийм эмэгтэй хүн хүртэл хүний хамгийн дээд дүр болох “Бурхан” болж чадна хэмээдэг учраас “Дэвадаттагийн тухай өгүүлэх бүлэг”-ийн энэ хэсэг мөн л урьд өмнө нь байгаагүй их тунхаглал болсон. Дэлхийн түүхэнд хамгийн анхны хүйсийн эрх тэгш байдлыг тодорхой өгүүлсэн нь энэ байсан гэдэг.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өнгөц харахад хэлбэр төрх, үр удмаа үлдээх үүрэг, ажил хөдөлмөрийн ялгаа болон хийж чадах, чадахгүй зүйл гэх мэт төрөлхийн ялгаа олон бий. Хэлбэр дүрсийн хувьд тийм ялгаатай эр, эм хүмүүс нь өөр өөрийн гэсэн байгалаас заяасан онцлог шинж чанараараа харилцан бие биенээ нөхөж, эвтэй дотно гэр бүлийг бий болгож, нийгмийг бүрдүүлэхэд эрэгтэй хүн ч, эмэгтэй хүн ч эрх тэгш оролцдог гэдгийг мартаж үл болно. Тиймээс онолын хувьд ч, нийгмийн оролцооны хувьд ч эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байдаг шалтгаан үүнд бий.

Үүнийг тухайн үеийн хүмүүс толгойгоороо ойлгож байсан ч, сэтгэлийн гүн дэх эмэгтэй хүнийг дорд үзэх үзэл нь бүрэн арилж өгөхгүй байсан. Тиймээс Шагжамүни бурхан нийгэмд эзлэх байр суурины эрх тэгш байдлаас улам цаашилж, хүн гэдэг үндсэн шинжийнх нь эрх



тэгш байдлыг “Бурханы хутгийг олох” гэсэн дээдийн дээд баталгаагаар дамжуулж илүү тодорхой болгосон. Өөрөөр хэлбэл “Хүйсээс үл хамааран, бүх хүн угаасаа эрх тэгш бурханлаг чанартай.” гэсэн үзэл, санааг тогтоож чадсан.

Нэг анхаарал татсан зүйл бол лусын охин эмэгтэй чигээрээ бус, эрэгтэй болж хувирч байж бурхан болсон явдал юм. Тухайн үеийн Энэтхэгчүүдийн сэтгэл зүйгээр бодоод үзвэл яагаад ингэсний учрыг шууд ойлгоно. Гүнзгий болох шаардлагагүй. Эмэгтэй хүн эрэгтэй болж хувираад бурханы хутаг олно гэсэн уран сайхны дүрслэлээр илэрхийлэх юм бол эмэгтэй хүнийг дорд үздэг үзэл санаа бат шингэсэн тэр үеийн хүмүүст илүү гүн сэтгэгдэл төрж, сургаалын утгыг сайн ойлгож чадах тул ийнхүү илэрхийлсэн.

Сүсэг бишрэлийн агуу хүч

Лусын ордноос ирсэн найман настай охин шууд бурханы гэгээрэлд хүрнэ гэдэг Шаарипүтра хүртэл итгэх аргагүй зүйл байсан. Үүгээр дараах зүйлийг сургасан.

Найман настай охиноор “Хүүхэд шиг цагаан цайлган сэтгэл”-ийг дүрсэлсэн. Лусын ордны ертөнцөөр хүний соёл иргэншлээс тэс өөр газрыг илэрхийлсэн ба энэ нь хүнээс бусад оршихуй ч гэсэн бурханы гэгээрэлд хүрч чадна



гэсэн утгатай. Мөн гурван мянган их мянган ертөнцөд үнэлэгдэх үнэт эрдэнийн сувд гэдэг нь “Сүсэг бишрэл”-ээс өөрцгүй юм.

Жаахан хүүхэд мэт цагаан цайлган сэтгэлээр бурханы сургаалд итгэсэн цагаас эхлэн бид бүхэн Бурхантай уусан нэгдэж, нэгэн бие болж чадна. Сансар огторгуй биднийх болно гэсэн үг. Тиймээс “Сүсэг бишрэл” бол яах аргагүй гурван мянган их мянган ертөнцтэй эн зэрэгцэхүйц үнэ цэнэтэй юм.

Тэрхүү үнэт эрдэнийн сувдыг Бурхан шууд хүлээн авсан гэдэг нь, “Бурханд сүсэглэх” тэр агшинд Бурхантай шууд холбогдож чадна гэсэн үг. Ийнхүү Бурхантай холбогдох нь бурханы хутаг олох хамгийн дөт зам юм.

Соёл иргэншил хөгжихийн хирээр хүмүүс зөвхөн учир шалтгаанаар шашны сургаалыг шүүмжлэх хандлагатай болдог. Онолын хувьд тодорхой байна гэдэг мэдээж хэрэг чухал боловч зөвхөн онол яриад байх юм бол зүрх сэтгэлийн угаас гэнэт гэгээрлийг олж, бурханы зам мөрд орно гэсэн гайхамшигт огт хүрч чадахгүй.

Харин лусын ертөнцийн найман настай охин шиг нялх бага, хангалттай боловсрол эзэмшээгүй хүн байлаа ч гэсэн хувийн бодлоо хаяж, цагаан цайлган сэтгэлээр бурханы сургаалд сэтгэлийнхээ угаас итгэх юм бол тэр байгаа чигээрээ жинхэнэ гэгээрлийн түвшинд хүрч чадна.

Бид ч мөн адил бурханы сургаалыг сурах тал дээр янз бүрийн тогтсон мэдлэг, үзэл санаа, биед нэвчсэн хандлагаа хаяж, цагаан цаас болон хүлээн авах нь чухал. Үүнийг энэхүү

“Дэвадаттагийн тухай өгүүлэх бүлэг” болон дараагийн “Судар барихуйг зоригжуулсныг өгүүлэх арван гурав дугаар бүлэг”-т өгүүлэх “Эмэгтэй хүн бурханы хутгийг олох тухай сургаал”-аар дамжуулж сайтар ойлгож авах хэрэгтэй.



Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 126-132

Нэг жилийг хэрхэн өнгөрүүлэх вэ?

Та бүхэнд шинэ жилийн мэнд хүргэе.

“Нэг жилийн өнгө шинийн нэгнээс” гэсэн үг байдаг. Жирийн л нэг жил байлгах уу, үр бүтээлтэй жил болгох уу гэдэгт гараа хамгийн чухал.

Нийгэмлэгийн ерөнхийлөгч 1-р сарын сургаалдаа “Энэ жилийг ямар жил болгох нь өөрөөс шалтгаална” хэмээн айлдсан. Түүнчлэн гойд авьяасгүй байсан Рахулагийн нүдэнд үл үзэгдэх бурханы үйлээс суралцаж, цагаан цайлган, даруу төлөв сэтгэлээр бурханы зам мөрд хичээж, үргэлж сургаалд суралцаж, хэрэгжүүлж байхын чухлыг өгүүлсэн.


“Жинхэнэ өөрийгөө олох” гэдэг нь бурханлаг чанарын сайхныг мэдэрч, шунал хүслээсээ ангижирахыг хэлнэ. Үүний тулд ч гэсэн цагаан цайлган, төлөв даруу байхаа маргалгүй, өнөөдөр нэг өдрийг аль болох гэгээлэг, амар амгалан өнгөрүүлэх чухал билээ.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Кооичи





Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA

TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633

Email: info@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA

TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA

TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA

POBox 33636, CA 90033, USA

TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567

Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA

POBox 778, Pacifica, CA 94044, USA

TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437

Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA

TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA

TEL: 1-773-842-5654

Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA

POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA

TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303

Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA

TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA

URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA

TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437

Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA

(Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA

TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745

Email: dharmasanantonio@gmail.com

URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA

TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261

Email: rkseattlewashington@gmail.com

URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil

TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377

Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar, New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo, Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunagar, P.S.: Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district, Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum, Orkhon province, Mongolia

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>